



MNAS AC08

МОНГОЛ УЛСЫН
ИТГЭМЖЛЭЛИЙН
ТОГТОЛЦОО

АВЛИГЫН ЭСРЭГ МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ИТГЭМЖЛЭЛИЙН ШАЛГУУР

Нэгдсэн үндэсний гудамж 5/1, 3Г-ын II байр
Улаанбаатар 15160, Монгол Улс
Утас: (976) 77073689

Цахим хуудас: www.mnas.gov.mn
Цахим шуудан: info@mnas.gov.mn

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

ХЭВЛЭСЭН ОГНОО:
01.11.2024

ӨӨРЧЛӨЛТ NO: 00
ӨӨРЧЛӨЛТИЙН ОГНОО: -

0 Оршил

Аж үйлдвэрийн салбар, менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор Монгол Улсын засгийн газар болон Үндэсний итгэмжлэлийн төв хамтарч Чанарын менежментийн тогтолцоо (ЧМТ), Байгаль орчны менежментийн тогтолцоо (БОМТ) болон бусад менежментийн тогтолцооны баталгаажуулалтын итгэмжлэлийн тогтолцоог бий болгохоор ажиллаж байгаа билээ.

MNAS нь аль хэдийнээ ЧМТ, БОМТ, ХАБМТ, ХЭМАБМТ болон МАБМТ-ны итгэмжлэлийн шалгууруудыг бий болгосон.

MNAS-ийн гаргаж буй Авлигын эсрэг менежментийн тогтолцооны итгэмжлэлийн шалгуурыг Монгол Улсад явагдаж буй баталгаажуулалтын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, гадаад улс болон бүс нутаг, олон улсын гэрээнд нэгдэх зорилгоор ISO/IEC 17021-1 болон ISO/IEC 17021-9 стандартын дагуу боловсруулсан. Итгэмжлэлийн шалгуурыг IAF/APAC-аас шинээр хэвлэгдсэн стандарт, заавал дагаж мөрдөх баримт бичгийн лавлагааг тусгах зорилгоор тогтмол шинэчилдэг.

1 Хамрах хэрээ

Энэхүү баримт бичиг нь Авлигын эсрэг менежментийн тогтолцоо (АЭМТ)-ны баталгаажуулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хөндлөнгийн байгууллагыг MNAS-аас Авлигын эсрэг менежментийн тогтолцооны баталгаажуулалтын үйл ажиллагааг явуулах чадвартай, найдвартай гэж үнэлэхэд тавигдах шаардлагыг тодорхойлно.

2 Шалгуур

- Авлигын эсрэг менежментийн тогтолцооны баталгаажуулалт хийх итгэмжлэл хүссэн Баталгаажуулалтын байгууллага нь ISO/IEC 17021-1 “Тохирлын үнэлгээ. Менежментийн тогтолцооны аудит болон баталгаажуулалтыг гүйцэтгэх байгууллагад тавих шаардлага. 1-р хэсэг Шаардлага” болон ISO/IEC 17021-9 “9-р хэсэг: Авлигын эсрэг менежментийн тогтолцооны аудит болон баталгаажуулалтад тавих чадавхын шаардлага” стандартад заасан шаардлагуудыг хангах үүрэгтэй.
- Баталгаажуулалтын тогтолцоог ISO 37001 стандартад заасан Авлигын эсрэг менежментийн тогтолцооны шаардлага эсвэл MNAS-ийн баталсан бусад эн тэнцүү баримт бичгийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг нь үнэлнэ.
- ISO/IEC 17021 болон ISO 37001 стандартын хувь, хуулбарыг Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)-аас авч болно.

Тайлбар: ISO/IEC 17021 болон ISO 37001 стандартын шинэчлэлийн хүрээнд IAF болон APAC-аас тогтоосон баримт бичигт өөрчлөлт орох бүрт MNAS нь итгэмжлэлийн шалгуурын нэг хэсэг болгон ашиглана.

3 ISO/IEC 27006-1 стандартын шаардлагын удирдамж

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AC08	Авлигын эсрэг менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн шалгуур	
Хэвлэсэн огноо: 01.11.2024	Өөрчлөлт No: 00	Хуудас: 1/6
	Өөрчлөлтийн огноо: -	

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

MNAS нь ISO/IEC 17021 стандартын шаардлага болон IAF-н заавал мөрдөх баримт бичгүүдийг нэмэлт шалгуурын баримт бичгээр ашиглана. Итгэмжлэлийн шалгуурын талаар тодруулга хэрэгтэй бол MNAS нэмэлт тайлбар өгнө.

Тайлбар: IAF-н заавал мөрдөх баримт бичгийг IAF цахим хуудаснаас англи, MNAS цахим хуудаснаас монгол хэлээр тус тус үнэгүй татаж авах боломжтой.

4 Итгэмжлэлийн хүрээ

MNAS нь энэ схемийн итгэмжлэлд холбогдох салбаруудыг итгэмжлэлийн хүрээгээр тодорхойлохгүй байхаар шийдсэн болно.

5 Баталгаажуулалтын байгууллага (ББ)-ын чадамж

MNAS-н итгэмжлэл нь тухайн баталгаажуулалтын байгууллага нь ISO/IEC 37001 Авлигын эсрэг менежментийн тогтолцооны баталгаажуулалтыг хийх чадавхтайг харуулна. Баталгаажуулалтын байгууллага нь Гуравдагч талын шударга, чадавхтай үнэлгээгээр Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо нь тогтоосон шаардлагыг хангаж буй итгэл найдварыг бүх талуудад өгөх үүрэгтэй.

Баталгаажуулалтын байгууллага нь аудитор, шинжээчдийнхээ анхдагч үнэлгээ, ур чадвар, гүйцэтгэл, мониторингийн талаар ISO/IEC 17021-1 стандартын А хавсралтад тусгасан болон ISO/IEC 17021-9, ISO 19011 стандартуудад үндэслэсэн баримтжуулсан журамтай байна. Баталгаажуулалтын байгууллага нь техникийн тодорхой хүрээнд аудитор / шинжээч бэлтгэх журамтай байна.

6 Баталгаажуулалтын байгууллагын Аудит хийх хугацаа

6.1 ISO эсхүл IAF-аас ISO 37001 стандартад нийцэж байгаа эсэхийг үнэлэх аудитад шаардлагатай хүн өдрийг тооцоолох баримт бичгийг гарч ирэх хүртэл MNAS нь IAF MD 05 баримт бичгийг ашиглана.

6.2 Баталгаажуулалтын байгууллага нь анхдагч баталгаажуулалт, магадлах хяналт, давтан баталгаажуулалт хийхэд шаардлагатай аудитын хүн өдрийг тодорхойлох журамтай байна. Уг журамд олон салбартай байгууллагад (multisite organisations) аудит хийх хугацааг тооцоолох, баталгаажуулалтыг шилжүүлэх тухай заалтуудыг оруулна. Аудитын хугацааг тодорхойлохдоо баталгаажуулалтын байгууллага нь АЭМТ-ны эрсдэлийн төвөгшлийн төрөл, хууль эрх зүйн (хууль болон зохицуулалтын) нийцлийн ач холбогдол, үр нөлөөтэй ажилтны тоог хамгийн багадаа багтааж авч үзсэн байна.

6.3 IAF MD 5 болон IAF MD 11 (хэрэв байх бол) баримт бичгийг хэрэглэнэ. Дараах АЭМТ I хүснэгтийг ашиглана. Гэхдээ энэ нь бууруулах хүчин зүйлд хамаарахгүй.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AC08	Авлигын эсрэг менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн шалгуур	
Хэвлэсэн огноо: 01.11.2024	Өөрчлөлт No: 00	Хуудас: 2/6
	Өөрчлөлтийн огноо: -	

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

Хүснэгт АЭМТ 1 - Үр нөлөөтэй ажилтны тоо, АЭМТ-ны эрсдэлийн төвөгшлийн төрөл ба аудитын хугацаа хоорондын хамаарал (Зөвхөн 1-р шат + 2-р шатыг багтаасан анхдагч аудитад)

Үр нөлөөтэй ажилтны тоо	Аудитын хугацаа 1-р шат + 2-р шат (өдрөөр)			Үр нөлөөтэй ажилтны тоо	Аудитын хугацаа 1-р шат + 2-р шат (өдрөөр)		
	Өндөр	Дунд	Бага		Өндөр	Дунд	Бага
1-5	3	2.5	2.5	626-875	17	13	10
6-10	3.5	3	3	876-1175	19	15	11
11-15	4.5	3.5	3	1176-1550	20	16	12
16-25	5.5	4.5	3.5	1551-2025	21	17	12
26-45	7	5.5	4	2026-2675	23	18	13
46-65	8	6	4.5	2676-3450	25	19	14
66-85	9	7	5	3451-4350	27	20	15
86-125	11	8	5.5	4351-5450	28	21	16
126-175	12	9	6	5451-6800	30	23	17
176-275	13	10	7	6801-8500	32	25	19
276-425	15	11	8	8501-10700	34	27	20
426-625	16	12	9	>10700	Прогресс цааш үргэлжлэнэ		

Тайлбар 1: Аудитын хугацааг өндөр дунд, бага гэсэн АЭМТ-ны эрсдэлийн төвөгшлийн төрөлд үзүүлээ.

Тайлбар 2: АЭМТ 1 хүснэгтэд заасан ажилтны тоог шатлалтай өөрчлөлтөөс илүүтэйгээр тогтмол өсөх байдлаар гарфик байдлаар үзэж эхлэлтийн цэгийг доод утгаар, тгөгчгөлийн цэгийг дээд утгаар нь авбал зохино. Графикийн эхлэлтийн цэг нь 1 ажилтанд харгалзах 2.5 өдөр гэснээс эхэлвэл зохино. IAF MD 5 баримт бичгийн 2.2-т хагас өдрийн талаар тусгасан.

Тайлбар 3: Байгууллагын ажилтны тоо 10700-аас илүү тохиолдолд аудитын цагийг тооцоолох журмыг боловсруулж болно. Энэ хугацаа нь АЭМТ 1 хүснэгтэд заасанчлан өсөх дарааллыг баримтлана.

6.4 АЭМТ-ны эрсдэлийн төвөгшлийн төрлийг дараахь үндэслэлээр үнэлнэ. Үүнд:

АЭМТ-ийн хувьд энэ баримт бичигт заасан заалтууд нь дараах эрсдэлийн хүчин зүйлсэд үндэслэн гурван үндсэн төвөгшлийн ангилалд хуваагдана. Үүнд:

- ~ **Газарзүйн байршил** (үйл ажиллагаа явуулж буй улсын/байршлын авлигын төсөөллийн индексээр тогтоосон эрсдэлийн түвшин);
- ~ **Байгууллагын өнгөрсөн байдал** (тодорхой хугацаанд гарсан хууль эрхзүйн хэргүүдийн тоо);
- ~ **Бизнесийн салбар** (авлигын төлбөрийн индексээр тодорхойлсон бизнесийн салбар дахь эрсдэлийн түвшин).

Дараах төвөгшлийн төрөл нь байгууллагын АЭМТ-ны эрсдэлд суурилсан бөгөөд аудитын хугацаанд үндсэн нөлөө үзүүлнэ. Үүнд:

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AC08	Авлигын эсрэг менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн шалгуур	
Хэвлэсэн огноо: 01.11.2024	Өөрчлөлт No: 00	Хуудас: 3/6
	Өөрчлөлтийн огноо: -	

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

Өндөр – Эрсдэл өндөртэй АЭМТ (ихэвчлэн авлигын төсөөллийн индекс (CPI) багатай орнуудад үйл ажиллагаа явуулдаг, авлигын түүхтэй, эсвэл авлигын индексээр өндөр эрсдэлтэй салбаруудад хамаарах).

Дунд – Эрсдэл дунд зэрэгтэй АЭМТ (ихэвчлэн CPI индекс дунд орнуудад үйл ажиллагаа явуулдаг, авлигын түүхгүй, авлигын индексээр дундаж эрсдэлтэй салбаруудад хамаарах).

Бага – Эрсдэл багатай АЭМТ (ихэвчлэн CPI өндөртэй орнуудад үйл ажиллагаа явуулдаг, авлигын түүхгүй, жижиг, дунд үйлдвэрүүд болон авлигын индексээр бага эрсдэлтэй салбаруудад хамаарах).

Хэрэв тухайн байгууллагын хувь эрсдэлүүд нь өөр өөр төвөгшлийн төрөлд хамаарах бол хамгийн өндөр төвөгшлийн төрлөөр авч үзнэ. Жишээлбэл, Энэтхэгт үйл ажиллагаа явуулдаг цахилгаан түгээх байгууллага нь "Өндөр" төвөгшлийн төрөлд хамаарна.

Тайлбар 4: CPI оноо гэдэг нь *"Авлигын төсөөллийн индекс"* бөгөөд улс орон/бүс нутгуудын авлигын төсөөллийн түвшинг харуулдаг үзүүлэлт юм. Transparency International байгууллагаас нийтэлдэг бөгөөд тухайн орны CPI оноо, зэрэглэлийг дараах холбоосоос харах боломжтой: <https://www.transparency.org/en/cpi>.

Тайлбар 5: Авлигын төлбөрийн индекс (Bribery Payer Index) нь *"Авлигын түвшин бизнесийн салбарт"* хэмээх Transparency International-ийн судалгаанд суурилсан бөгөөд аль салбар авлига өгөх магадлал өндөртэйг тодорхойлж, эрэмбэлдэг. 2011 оны BPI зэрэглэл дараах холбоосоор харах боломжтой: <https://www.transparency.org/en/publications/bribe-payers-index-2011>.

АЭМТ 1 хүснэгт нь дээрх гурван төвөгшлийн дээд ангилал болох өндөр, дунд, ба бага түвшнийг хамарна. АЭМТ 2 хүснэгт нь эдгээр төвөгшлийн гурван ангиллыг газарзүйн байршил болон бизнесийн салбаруудтай хэрхэн холбогдож байгааг харуулна.

Хүснэгт АЭМТ 2 – Газарзүйн байршил, байгууллагын өнгөрсөн байдал, бизнесийн салбар болон АЭМТ эрсдэлийн төвөгшлийн ангиллын хоорондын холбооны жишээ

АЭМТ-ны эрсдэлийн төвөгшлийн төрөл	Эрсдэлийн хүчин зүйл
Өндөр	Газарзүйн байршил - CPI оноо 30 буюу түүнээс бага улсад байрладаг байгууллагууд. Хэрэв тухайн компани хэд хэдэн улсад үйл ажиллагаа явуулдаг бол хамгийн бага CPI оноотой улсын индексийг хэрэглэнэ. Байгууллагын өнгөрсөн байдал Өнгөрсөн 5 жилийн хугацаанд авлига/хээл хахуультай холбоотой зөрчилтэй гэж үзэн хуулийн хариуцлага хүлээсэн, зохицуулалтын арга хэмжээ авхуулсан байгууллагууд. Бизнесийн салбар • Олон нийтийн, нийгмийн ажлууд, барилга байгууламж • Олон нийтийн үйлчилгээ (utilities) • Үл хөдлөх хөрөнгө, өмч, хууль эрх зүй, бизнесийн үйлчилгээ

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AC08	Авлигын эсрэг менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн шалгуур	
Хэвлэсэн огноо: 01.11.2024	Өөрчлөлт No: 00	Хуудас: 4/6
	Өөрчлөлтийн огноо: -	

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

	• Газрын тос, хий • Уул уурхай • Эрчим хүч үйлдвэрлэл ба дамжуулалт • Эмийн болон эрүүл мэндийн салбар • Хүнд үйлдвэрлэл • Загас агнуур • Зэвсэг, батлан хамгаалах болон цэргийн салбар • Засгийн газрын бүрэн эсвэл хэсэгчилсэн хяналттай байгууллагууд • Улс төрийн намууд, үйлдвэрчний эвлэлүүд
Дунд	Газарзүйн байршил - CPI оноо 31-59 хооронд улсад байрладаг байгууллагууд. Хэрэв тухайн компани хэд хэдэн улсад үйл ажиллагаа явуулдаг бол доод оноотой улсын индексийг хэрэглэнэ. Биенесийн салбар • Тээвэр, агуулах • Харилцаа холбоо • Хэрэглэгчийн үйлчилгээ • Ойн аж ахуй • Банк, санхүү • Мэдээллийн технологи • Иргэний сансрын салбар • Худалдаа, зуучлал, арилжааны компаниуд (ЖДҮ ангилалд багтахгүй) • Төрийн бус байгууллагууд, үндэсний зөвлөлүүд, холбоо, сангууд, ашгийн бус байгууллагууд (жишээ нь: сайн дурын байгууллагууд, хамтын ажиллагааны байгууллагууд)
Бага	Газарзүйн байршил - CPI оноо 60-аас дээш улсад байрладаг байгууллагууд. Хэрэв тухайн компани хэд хэдэн улсад үйл ажиллагаа явуулдаг бол хамгийн бага CPI оноотой улсын индексийг хэрэглэнэ. Биенесийн салбар • Хөнгөн үйлдвэрлэл • Хөдөө аж ахуй • Жижиг, дунд үйлдвэр (ЖДҮ) • Өндөр болон дунд төвөгшлийн ангилалд багтаагүй байгууллагууд

Тайлбар 6: Огноо заагаагүй эшлэлийн хувьд эш татсан баримт бичгийн хамгийн сүүлийн хэвлэл (аливаа нэмэлт өөрчлөлтийн хамт)-ийг хэрэглэнэ.

---XXX---

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AC08	Авлигын эсрэг менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн шалгуур	
Хэвлэсэн огноо: 01.11.2024	Өөрчлөлт No: 00	Хуудас: 5/6
	Өөрчлөлтийн огноо: -	

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

Өөрчлөлтийн бүртгэл

<u>Өөрчлөлт No.</u>	<u>Огноо</u>	<u>Баталсан</u>	<u>Гарсан өөрчлөлт</u>
-	-	-	-

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AC08	Авлигын эсрэг менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн шалгуур	
Хэвлэсэн огноо: 01.11.2024	Өөрчлөлт No: 00	Хуудас: 6/6
	Өөрчлөлтийн огноо: -	

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ